ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022/39/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Эрдэнэт хот<br>2022 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Ц.Нармандах<br>Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Эрдэнэ<br>Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br>Аудитор: Б.Оюунтуяа<br>Утас: 70350757 Цахим хаяг:oyuntuya0428@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....................................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .................................................... 3
3. Аудитын тайлан.........................................................................................................11
3.1 Ерөнхий зүйл........................................................................................................12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..........................................................12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..............................................................12
3.4 Материаллаг байдал ...............................................................................................12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..........................................................................13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..........................................................13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.................................................14
3.8 Аудитын гол асуудал ...............................................................................................14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...................14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................................14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..................................................................15
4. Аудитын илрүүлэлт ..................................................................................................15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ...............................................................16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2022.02.25 № 64
танай ____________-ны № ____________-т

ОРХОН АЙМГИЙН 5 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.АЛТАНЗУЛ ТАНАА

## Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,281,564.29** | **46,676,944.29** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 767.00 | 767.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | | |
| 31120 | Гадаад валют | | |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | | |
| 31140 | Касс арилжааны банк | | |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 767.00 | 767.00 |
| **3121** | **Төгрөг** | 767.00 | 767.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31212 | Монгол банкин дахь харилцах | | |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 767.00 | 767.00 |
| **336** | **Зээлийн авлага** | - | - |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,280,797.29 | 46,676,177.29 |
| **351** | **Түүхий эд материал** | 42,626,739.07 | 42,922,919.07 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 41,701,734.07 | 42,455,834.07 |
| 35130 | Эм боох материал | 925,005.00 | 467,085.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | |
| **354** | **Хангамжийн материал** | 5,654,058.22 | 3,753,258.22 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,298,800.00 | 2,925,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,350,258.22 | 600,058.22 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 228,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,413,607,545.55** | **1,380,618,695.15** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,413,607,545.55 | 1,380,618,695.15 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,185,847,545.55 | 1,152,858,695.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,180,538,712.51 | 1,180,538,712.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (54,882,932.32) | (83,143,492.72) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | |

| | | | |
|---|---|---|---|
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 25,737,629.04 | 29,303,119.04 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (14,660,655.88) | (17,794,795.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 73,170,242.00 | 76,294,222.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (40,210,013.76) | (46,037,652.63) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 21,066,527.80 | 21,066,527.80 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,911,963.84) | (7,367,945.76) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | | |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 227,760,000.00 | 227,760,000.00 |
| 39301 | Програм хангамж | 475,000.00 | 475,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (475,000.00) | (475,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 227,760,000.00 | 227,760,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,461,889,109.84** | **1,427,295,639.44** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **90.00** | **90.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 90.00 | 90.00 |
| 41224 | Төслийн зээл | | |
| 41225 | Бусад гадаад эх үүсвэрээс | | |
| **413** | **Өглөг** | 90.00 | 90.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 90.00 | 90.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 90.00 | 90.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,042,592,621.84** | **1,427,295,549.44** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,042,592,621.84 | 1,427,295,549.44 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 419,296,398.00 |
| 51101 | Өмч: - төрийн | | 419,296,398.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (19,253,929.78) | (53,847,400.18) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (19,253,929.78) | (19,253,929.78) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (34,593,470.40) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,061,846,551.62 | 1,061,846,551.62 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,042,592,711.84** | **1,427,295,639.44** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **434,552,460.00** | **408,975,570.00** |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | | |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **26,588,860.00** | **11,081,170.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 26,588,860.00 | 11,081,170.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 26,588,860.00 | 11,081,170.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 26,588,860.00 | 11,081,170.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **407,963,600.00** | **397,894,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 365,693,200.00 | 355,199,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 365,693,200.00 | 355,199,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 425,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 425,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 42,270,400.00 | 42,270,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 42,270,400.00 | 42,270,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **448,647,673.87** | **443,569,040.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **448,647,673.87** | **443,569,040.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 428,848,767.31 | 422,583,860.72 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 297,383,900.00 | 294,079,489.16 |
| 210101 | Үндсэн цалин | 197,219,651.50 | 189,465,786.36 |
| 210102 | Нэмэгдэл | 74,591,737.00 | 80,085,738.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,160,000.42 | 848,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,412,511.08 | 23,679,963.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,230,448.44 | 36,836,970.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,744,557.62 | 25,104,340.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,966,600.00 | 3,022,205.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,373,300.00 | 2,323,644.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 610,189.55 | 577,668.91 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,535,801.27 | 5,809,111.03 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,549,401.00 | 24,039,260.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,911,411.00 | 4,285,826.03 |
| 210302 | Түлш, халаалт | 12,373,714.00 | 15,638,441.82 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,264,276.00 | 4,114,993.02 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,900,164.00 | 6,892,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 4,095,880.00 | 2,361,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 78,300.00 | 63,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 23,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,742,484.00 | 2,360,140.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,983,500.00 | 2,083,460.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,895,575.00 | 18,328,320.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 87,935.00 | 96,480.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,700,940.00 | 17,766,340.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 106,700.00 | 465,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 914,100.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 914,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 40,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 40,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 720,000.00 | 35,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 35,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 39,169,278.87 | 41,417,520.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 930,760.00 | 1,739,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 38,238,518.87 | 39,678,320.40 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19,798,906.56 | 20,985,179.68 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 19,798,906.56 | 17,089,039.13 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | | |
| 213402 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад | | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,798,906.56 | 17,089,039.13 |
| 213404 | Хөрөнгийн | | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 3,896,140.55 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,896,140.55 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(14,095,213.87)** | **(34,593,470.40)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(14,095,213.87)** | **(34,593,470.40)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C 08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **419,296,398.00** | **1,061,846,551.62** | **(19,253,929.78)** | 1,461,889,019.84 |
| D 01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **419,296,398.00** | **1,061,846,551.62** | **(19,253,929.78)** | 1,461,889,019.84 |
| D 02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D 03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **419,296,398.00** | **1,061,846,551.62** | **(19,253,929.78)** | 1,461,889,019.84 |
| D 08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (34,593,470.40) | (34,593,470.40) |
| D 09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **419,296,398.00** | **1,061,846,551.62** | **(53,847,400.18)** | 1,427,295,549.44 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **407,963,600.00** | **397,894,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **407,963,600.00** | **397,894,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 365,693,200.00 | 355,199,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 365,693,200.00 | 355,199,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 425,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 425,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 42,270,400.00 | 42,270,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 42,270,400.00 | 42,270,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **407,963,600.00** | **397,894,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **407,963,600.00** | **397,894,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **388,164,693.44** | **376,909,220.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 297,383,900.00 | 294,079,489.16 |
| 210101 | Үндсэн цалин | 189,414,000.00 | 189,465,786.36 |
| 210102 | Нэмэгдэл | 82,380,499.37 | 80,085,738.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,160,000.00 | 848,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,429,400.63 | 23,679,963.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,230,448.44 | 36,836,970.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,494,552.97 | 25,702,047.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,956,241.49 | 2,809,222.93 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,341,173.25 | 2,220,758.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 584,997.68 | 553,396.06 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,853,483.05 | 5,551,545.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,549,401.00 | 24,039,260.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,911,411.00 | 4,285,826.03 |
| 210302 | Түлш, халаалт | 12,373,714.00 | 15,638,441.82 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,264,276.00 | 4,114,993.02 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,624,924.00 | 1,141,860.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 96,700.00 | 249,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 78,300.00 | 63,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 49,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,275,824.00 | 636,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 174,100.00 | 142,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,955,720.00 | 18,242,240.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 150,600.00 | 45,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,271,320.00 | 17,761,340.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 533,800.00 | 435,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,142,100.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,142,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 40,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 40,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 720,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,700,300.00 | 1,387,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,700,300.00 | 1,387,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,798,906.56** | **20,985,179.68** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 18,720,999.00 | 17,089,039.13 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,720,999.00 | 17,089,039.13 |
| 213404 | Хөрөнгийн | | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,077,907.56 | 3,896,140.55 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,077,907.56 | 3,896,140.55 |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 250005 | Төлсөн ногдол ашиг | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 767.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 767.00 | 767.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 401727000.00 | 376484220.32 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 401727000.00 | 376484220.32 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 401727000.00 | 376484220.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 282643500.00 | 294079489.16 |
| 210101 | Үндсэн цалин | 161857800.00 | 189465786.36 |
| 210102 | Нэмэгдэл | 95735100.00 | 80085738.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2535300.00 | 848000.00 |
| 210104 | Урамшуулал | 22515300.00 | 23679963.88 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38161300.00 | 36836970.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26843600.00 | 25702047.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2829500.00 | 2809222.93 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2263400.00 | 2220758.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 566000.00 | 553396.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5658800.00 | 5551545.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41128300.00 | 24039260.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10024700.00 | 4285826.03 |
| 210302 | Түлш, халаалт | 18831400.00 | 15638441.82 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12272200.00 | 4114993.02 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 807000.00 | 716860.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 92100.00 | 74500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 74,400.00 | 63,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 49,400.00 | 49,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 420,600.00 | 386,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 170,500.00 | 142,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 35,358,700.00 | 18,242,240.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,400.00 | 45,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,877,800.00 | 17,761,340.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 435,500.00 | 435,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,598,900.00 | 1,142,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 1,598,900.00 | 1,142,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 80,600.00 | 40,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 80,600.00 | 40,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 561,400.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 561,400.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,387,300.00 | 1,387,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,387,300.00 | 1,387,300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 402,855,000.00 | 376,484,220.32 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 360,127,800.00 | 351,302,859.45 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 360,127,800.00 | 351,302,859.45 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 42,727,200.00 | 25,181,360.87 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 42,727,200.00 | 25,181,360.87 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **767.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **767.00** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **425,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **425,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 425,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 425,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 175,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 250,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 425,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 5-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Оюунтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 5-р цэцэрлэг нь багшийн хөгжил, би монгол хүүхэд, хөдөлгөөн эрүүл мэнд, хүүхдэд ээлтэй орчин дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлэн, сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, БШУЯ-ны харьяа төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт орлогын 1.5 хувиар буюу 5,962.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,173.4 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 5-р цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,593.5 мянган төгрөг буюу 3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан үндсэн хөрөнгө байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Бараа материал | 48,280.8 | 46,676.2 | -1,604.6 |
| Үндсэн хөрөнгө | 1,413,607.5 | 1,380,618.7 | -32,988.8 |
| **Нийт хөрөнгө** | **1,461,889.1** | **1,427,295.6** | **-34,593.5** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,461,889.1 | 1,427,295.6 | -34,593.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,461,889.1 | 1,427,295.6 | -34,593.5 |

Бараа материалын данс 46,676.2 мянган төгрөг болж 1,604.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны бараа материалыг зарлагдсанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,380,618.7 мянган төгрөг болж 32,988.8 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,427,295.6 мянган төгрөг болж 34,593.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн 5-р цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 401,727.0 мянган төгрөг, нийт зарлагыг 401,727.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 4,257.6 мянган төгрөгөөр бууруулан 397,469.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 355,199.0 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 42,270.4 мянган төгрөгийн нийт 397,469.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 376,484.2 мянган төгрөгийг зарцуулж, 20,985.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 376,484.2 мянган төгрөг буюу 95 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17,089.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,896.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт дансаар 425.0 мянган төгрөг хүлээн авч урсгал үйл ажиллагаандаа зориулалтын дагуу зарцуулсан байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн 5-р цэцэрлэг нь 2021 онд нийт 376,484.2 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээсэн байна, харин зарлагын гүйлгээ хийхдээ Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 54,494.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Зөвлөмж | 3 | 52,135.9 | 3 | 52,135.9 | | | |
| Албан шаардлага | 1 | 2,358.2 | 1 | 2,358.2 | | | |
| Нийт дүн | 4 | 54,494.1 | 4 | 54,494.1 | | | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 87.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 87.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Албан шаардлага

Тайлант онд 87.1 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.*

### 4.3 Зөвлөмж

***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:*

2021 оны 1 сард нярав солигдсон байтал эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12.2.2.-д " Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед тооллого хийнэ"; 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэж заасантай нийцэхгүй.

1.2 *Өгсөн зөвлөмж*

Захирал, нягтлан бодогч, нярав солигдох үед эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орхон аймгийн 5-р цэцэрлэг | 2 | 87.1 | | | | | 1 | 87.1 | 1 | 0 |